



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/30

Жаргалант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн ээлжит гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Норовлин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.5.3, 3.3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улс, аймаг, сумын аварга малчин, саальчин, алтан төлийн эзэн, аймгийн арслан цолтон, Монгол Улсын гарамгай мэргэн харваач нарт хүндэтгэл үзүүлэхэд 4,930,000 (дөрвөн сая есөн зуун гучин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулсугай.


2.Ахмад настнуудын дунд зохион байгуулсан софт волейболын шагнал, хүндэтгэлийн тоглолтын зардал нийт 1,900,000 (нэг сая есөн зуу) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас зарцуулсугай.

3.Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулах зардлыг нэгдүгээр хавсралтаар, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас зарцуулах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Засаг даргын Тамгын газрын шатахууны зардал хүрэлцэхгүй байгаа тул 1,338,480 (нэг сая гурван зуун гучин найман мянга дөрвөн зуун наян) төгрөгийг эрсдэлийн сангаас зарцуулсугай.

5.Дээрх зардлыг холбогдох зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Л.Энхдорж)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232501077



CLINICAL

А. Жазаров

Сумын Засаг даргын 2025 оны 02
дугаар сарын 25-ны өдрийн А/30 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГӨНӨӨС
ЗАРЦУУЛАХ ТООЦОО

№	Зардлын нэр	Нийт үнэ (төгрөг)
1	Сумын аваргын цом /нөөц/	1,485,000
2	Улс, аймгийн аварга малчинд олгох гарын бэлэг	1,162,000
3	Бийрэн бичлэг	730,000
4	Аймгийн арслан А.Эрдэнэбаярт хүндэтгэл үзүүлэх	673,000
5	Сумын харъяат Монгол улсын гарамгай мэргэн харваач С.Наранбаярт хүндэтгэл үзүүлэх	330,000
6	01 сарын 25-ний ахмадын өдөрлөг зохион байгуулах зардал	550,000
	Нийт дүн	4930,000

Сумын Засаг даргын 2025 оны 02
дугаар сарын 25-ны өдрийн А/30 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ЗАСАГ ДАРГЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛААС
ЗАРЦУУЛАХ ТООЦОО

№	Зардлын нэр	Нийт үнэ (төгрөг)
1	Ахмадын софт волейболын тэмцээний шагнал	900,000
2	"Малчны алдар" шагнал гардуулах хүндэтгэлийн тоглолтын хөлс	1,000,000
	Нийт дүн	1,900,000

